

АУДИТЫН КОД: САГ-2018/28/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор: Р.Цолмон

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn


Гэрээт ажилтан: Э.Ундармаа

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	8
3	АУДИТЫН ТАЙЛАН	10
3.1	Оршил.....	10
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	10
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	11
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	11
3.5	Дотоод хяналт	12
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
3.7	Шилэн дансны мэдээлэл	14
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	14
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	14
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	14
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	16
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	16
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	16
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	17
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	17
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	18
3.16	Үр өгөөжийн тооцоолол.....	18
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	19
4.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын талаар.....	20
4.2	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	21
4.3	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан.....	22
4.4	Хөтөлбөр арга хэмжээ.....	23
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	24
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	24
5.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	25
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	26
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	27
5.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	28
6	АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГС ААЛТ	31
7	АЛБАН ШААРДЛАГА.....	33





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1030

танай _____-ны № _____-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД Б.БАТЗОРИГ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлуудын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG20.Docx

077452

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2018\0425SAG20.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд өглөг, авлагыг барагдуулах, тулган баталгаажуулалт хийх, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт ажилтан С.Ундармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1084 дугаар албан бичгээр, Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- Хүнсний аюулгүй байдлын асуудал;
- Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- Газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- Мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- Мал, амьтан ургамлын хорио цээрийн бодлого зэрэг болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид ХХААХҮЯ гэх/ тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 400 арга хэмжээ төлөвлөснөөс 83.4 хувийн биелэлттэй байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар товчоолов. Тухайлбал,

- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 121 арга хэмжээний биелэлт 83.5 хувь;
- Засгийн газрын тогтоолоор баталсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 хөтөлбөрийг ХХААХҮЯ удирдан хэрэгжүүлжээ. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд нийт 279 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 83.6 хувь;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 191 арга хэмжээний биелэлт 60.3 хувь байна.

ХХААХҮЯ-ны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 11 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 18 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-тай нийцэхгүй болсон тул уг баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн тайлагналын зорилгоор хяналтанд байгаа төсөвт байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайланг толилуулах талаар тусгах;
- УСНББОУС 6 “Нэгтгэсэн тайлан болон тусдаа санхүүгийн тайлан” гэсэн стандартыг нэмж тусгах;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх холбогдох УСНББОУС-аар цэвэр дүнг гаргахыг шаардсан эсвэл тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө, өр төлбөр эсвэл орлого, зардлыг цэвэр дүнгээр гаргахгүй байх талаар тусгах бодлого зэрэг болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод хяналт


Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тус газар салбарын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, төслийн арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагаар хангах зорилгын дор тайлант онд салбарын байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, гарч бодох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дотоод аудитыг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлэн ажиллажээ.



Хүснэгт №1 **Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт**

№	ҮЗҮҮЛЭЛТ		ДҮН
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо		6
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо		9
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо		47
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	87
		Дүн (сая.төг)	1,799.0
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	5
		Дүн (сая.төг)	753.5
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	4 акт, 3 албан шаардлага
		Дүн (сая.төг)	1,045.5

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны тайлан

Өглөг, авлагыг баталгаажуулаагүй, хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, цалинг зөрүүтэй олгосон, гэрээний дагуу аж ахуйн нэгж, иргэдээс урьдчилгаа, төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүр аудитын хорооны тогтоол гарган ажиллажээ.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд өмнөх зөвлөмжийн биелэлтийн хувь өссөн байна.

Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд системийн хэмжээгээр эрсдэл бага, дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тайлант онд хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.


Дээрх хуулиар ХХААХҮЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээг 105,905.8 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 113,658.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 225,085.6 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 107,339.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 55,634.9 сая төгрөгийг баталсан байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 10 дугаар сард батлагдсан хуулиар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудыг 277,085.6 сая төгрөгөөр батлагдсан боловч дотоодын эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлтөөр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 52,000.0 сая төгрөгөөр төлөгдөх дүнгээр хорогдуулж төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд төлөвлөгөөг 225,085.6 сая төгрөгөөр тусгасан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 98.3 хувь буюу 4,603.9 сая төгрөгөөр хэмнэлттэй байна. Урсгал зардалд 99,500.8 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 7,838.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 48,939.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 6,695.8 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар хэтэрсэн зардал байхгүй байна.



Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргасан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

ХХААХҮЯ өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Хөрөнгө оруулалт худалдан авалт тендертэй холбоотой;
2. Төсөв гүйцэтгэлтэй холбоотой;
3. Бусад мэдээлэл зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

3.9.1.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа байгууллагуудын 37 байгууллага нь аудитад хамрагдсан бөгөөд 32 байгууллага “Зөрчилгүй”, 3 байгууллага “Хязгаарлалттай”, 2 байгууллага “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагууд:

- Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар-/3.0 сая төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй, бараа материалын 91.1 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан, шатахууны зардлыг 16.6 сая төгрөгийг зарцуулалтыг бүрэн баталгаажуулаагүй гэх мэт/
- Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар-/Санхүүгийн тайланд өглөг, авлага их хэмжээгээр үлдэгдэлтэй/
- Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-/санхүүгийн тайланд тусгасан автомашин биетээр байхгүй, 9.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, iPhone гар утас дутагдсан гэх мэт/

01

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

“Сөрөг” санал, дүгнэлт авсан байгууллагууд:

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан-/Зээлийн санхүүжилтийг 4,615.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн, төсөл, сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу явуулаагүй, 7,024.3 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлээгүй, санхүүгийн тайланд 1,189.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг тусгаагүй гэх мэт/
- Биокомбинат ТӨААТҮГ-/Орлогын төлөвлөгөөг 789.7 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн, 102.9 сая төгрөгийн авлага, 40.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 151.7 сая төгрөгийн бараа материалыг илүү бэлтгэсэн, үр ашиггүй 32.2 сая төгрөгийг зарцуулсан гэх мэт/

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн “Хязгаарлалттай”, “Сөрөг” аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 183,629.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 170,285.7 сая төгрөгийн алдааг залруулж, 17.9 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт, 1,446.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлага өгч, 107.7 сая төгрөгийн зөрчил гаргасан 4 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 11,772.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгсөн байна.

3.9.1.2 Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өглөгөөр тусгасан 27,311.1 сая төгрөг нь Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас авсан 80.9 мянган тонн улаан буудайны улсын төсөвт төвлөрүүлэх ёстой үлдэгдэл төлбөр болно. Уг өглөгийг улаан буудайн хадгалалтын зардал, худалдах, худалдан авах үнийн зөрүүнээс үүссэн алдагдал, хэвийн хорогдол зэргийг тооцож Сангийн яамтай өнөөг хүртэл тулган баталгаажуулалт хийгээгүйгээс шалтгаалан барагдуулаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуулийг баримтлан ажиллаж, Сангийн яамтай Монгол Улсыг хөгжүүлэх сангийн улаан буудайн тооцоог хийж, улсын төсөвт төвлөрүүлэх, өглөгийг барагдуулах арга хэмжээ авах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.9.1.3 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаар

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2009 оноос хойш олгосон Арилжааны банкнаас авах зээлийн авлага, Ахуй үйлчилгээний төв болон бөөний худалдааны зээл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдсэн холбоо, Сүү төслийн болон Түүхий эдийн төв байгуулах, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/-уудын тушаалуудаар олгосон зээл зэрэг нийт 274,025.7 сая төгрөгийн авлага тусгагдсаны 2.6 хувь буюу 7,024.3 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг



гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо нийлээгүй зээл болон зээлийн хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг баталгаажуулах, барагдуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитад Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэгдсэн 4 байгууллага, төсөл хөтөлбөрийн нэгжид түүвэр хэлбэрээр хамруулсан бөгөөд аудитын явцаар нийт 103,932.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг арилгах 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.2.1 Хөтөлбөр, арга хэмжээний зардлын талаар

ХХААХҮЯ "Сайнза интернэшнл" ХХК-тай 2016 оны 5 дугаар сард 31.9 сая төгрөгийн “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний 2 дугаар хэсгийн 4-т “...ХХААХҮЯ нь гэрээний 1.1-ийн b, d заалтад заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэнэ” гэж заасан боловч дээрх гэрээгээ дүгнээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, гэрээний заалтыг мөрдөн ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Дээрх аудитаар илэрсэн нийтлэг алдаа, зөрчлийг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Харилцагч байгууллагуудтай хийсэн гэрээгээ дүгнэж байх;
- Авлага, өглөгийг барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах талаар арга хэмжээ авах;
- Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зэрэг болно.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын Үндэсний аудитын газарт ирүүлсэн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг харьяа байгууллагуудын аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзэлтэй тулган баталгаажуулахад зөрүү гарч, хэд хэдэн удаа засагдсанаас шалтгаалан хугацаа их алдаж, аудитад хүндрэл учирч байлаа.

Энэ нь тус сайдын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байгаа албан тушаалтантай холбоотой бөгөөд буруу илэрхийлэгдэх эрсдэлийг үүсгэж байгаа тул холбогдох байгууллага анхааралдаа авах нь зүйтэй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- ХХААХҮЯ, Худалдаа хөгжлийн банк хооронд байгууллагын “Зээлийн бхүүний хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх гэрээ”-ний 3.7-д “Зээлдэгч нь мал, мах худалдан авсан төлбөрийг Гэрээний 3.5-т заасан данснаас зөвхөн малны дансанд шилжүүлэх ...”, ХХААХҮЯ, Үйлдвэр аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан

"Мал мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх, түүнийг хадгалах, худалдан борлуулах гэрээ"-ний 2.2-т "Зээлдэгч нь дараах баримтыг үндэслэн мал, мах худалдан авсан төлбөрийг зөвхөн малчны дансанд шилжүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж Худалдаа хөгжлийн банк "Дархан meat фүүдс" ХХК-нд 745.3 сая төгрөгийг, "Хүнс комплекс" ХХК-нд 2.6 сая төгрөгийг, "Дельта холдинг" ХХК-нд 8,000.0 сая олгосон байна.

Дээрх гэрээний үүргээ биелүүлээгүй байхад ХХААХҮЯ Худалдаа хөгжлийн банкны 2017 оны 10 дугаар сарын 6/494/1706 дугаар албан тоотыг үндэслэн үлдэгдэл хүүний хөнгөлөлт болох 323.8 сая төгрөгийг "Дархан meat фүүдс" ХХК, "Хүнс комплекс" ХХК, "Дельта холдинг" ХХК-ны дансанд тус тус шилжүүлсэн нь дээрх гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т заасан "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам...зээлийн хүүний 10 нэгж хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг банкинд байршуулна" гэсэн байна.

Иймд цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний биелэлт болон Худалдаа хөгжлийн банкнаас олгосон дээрх хөрөнгийг бүрэн баталгаажуулж чадаагүй тул 2018 оны завсрын болон санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хамруулан үзэх.

- Тус Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудыг 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 183,629.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 103,932.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар нягтлан бодох бүртгэлийн 103,900.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 31.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлээ.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 41 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 79,697.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар 66,385.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 17.9 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 15 төлбөрийн акт тогтоож, 1,446.1 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага өгч, 107.7 сая төгрөгийн зөрчил гаргасан 4 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 11,740.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 87 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 90.0 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/2490 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгосон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 747,863.1



сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь 14,957.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 13,343.7 сая төгрөгийн санхүүгийн, 170,285.7 сая төгрөгийн санхүүгийн бус үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

**4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын
талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 183,629.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 170,285.7 сая төгрөгийн алдааг залруулж, 17.9 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт, 1,446.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлага өгч, 107.7 сая төгрөгийн зөрчил гаргасан 4 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 11,772.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх, биелүүлэн ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2 Тариалан эрхлэлтийг дэмжих сан

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өглөгөөр тусгасан 27,311.1 сая төгрөг нь Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас авсан 80.9 мянган тонн улаан буудайны улсын төсөвт төвлөрүүлэх ёстой үлдэгдэл төлбөр болно. Уг өглөгийг улаан буудайн хадгалалтын зардал, худалдах, худалдан авах үнийн зөрүүнээс үүссэн алдагдал, хэвийн хорогдол зэргийг тооцож Сангийн яамтай өнөөг хүртэл тулган баталгаажуулалт хийгээгүйгээс шалтгаалан барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Холбогдох хуулийг баримтлан ажиллаж, Сангийн яамтай Монгол Улсыг хөгжүүлэх сангийн улаан буудайн тооцоог хийж, улсын төсөвт төвлөрүүлэх, өглөгийг барагдуулах арга хэмжээ авах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

Эрх ба үүрэг-Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, төлөх үүрэгтэй байна.

Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4.3 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2009 оноос хойш олгосон Арилжааны банкнаас авах зээлийн авлага, Ахуй үйлчилгээний төв болон бөөний худалдааны зээл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдсэн холбоо, Сүү төслийн болон Түүхий эдийн төв байгуулах, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/-уудын тушаалуудаар олгосон зээл зэрэг нийт 274,025.7 сая төгрөгийн авлага тусгагдсаны 2.6 хувь буюу 7,024.3 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Тооцоо нийлээгүй зээл болон зээлийн хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг баталгаажуулах, барагдуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

Эрх ба үүрэг-Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, төлөх үүрэгтэй байна.

Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4.4 Хөтөлбөр арга хэмжээ

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам "Сайнза интернэшнл" ХХК-тай 2016 оны 5 дугаар сард 31.9 сая төгрөгийн "Мах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний 2 дугаар хэсгийн 4-т "...ХХААХҮЯ нь гэрээний 1.1-ийн b,d заалтад заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэнэ" гэж заасан боловч дээрх гэрээгээ дүгнээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Холбогдох хууль, гэрээний заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	609,626,606.5	618,556,276.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,538,556.5	41,950,928.1
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
АВЛАГА	506,254,596.1	502,432,760.2
УРЬДЧИЛГАА	504,386.0	503,560.9
БАРАА МАТЕРИАЛ	45,987,777.0	37,265,435.2
НӨӨЦИЙН БАРАА	44,341,290.8	36,403,591.9
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	74,539,921.4	129,306,785.6
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	56,655.6	192,939.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	74,483,265.8	129,113,846.5
Биет хөрөнгө	73,872,929.6	127,184,097.7
Биет бус хөрөнгө	610,336.2	281,858.3
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	684,166,528.0	747,863,061.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	448,237,162.8	439,081,965.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	348,570,306.8	167,526,978.6
Богино хугацаат зээлийн өглөг	340,578.6	455,360.9
Өглөг	346,235,805.4	162,886,544.8
Урьдчилж орсон орлого	1,993,922.8	4,185,072.8
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	99,666,856.1	271,554,986.8
Урт хугацаат зээл	99,666,856.1	141,404,252.6
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	235,929,365.1	308,781,096.5
Засгийн газрын хувь оролцоо	235,929,365.1	308,781,096.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	105,648,277.5	105,648,757.5
Хуримтлагдсан үр дүн	120,037,707.0	192,694,127.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,282,051.6	4,256,939.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	684,166,528.0	747,863,061.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	163,266,099.7	211,377,548.8
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
Бусад татвар, төлбөр, хураамж	-	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,027,812.4	88,043,775.9
Нийтлэг татварын бус орлого	37,463,902.7	77,928,730.9
Хөрөнгийн орлого	-	-
Тусламжийн орлого	10,563,909.6	10,115,045.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,238,287.4	123,333,772.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	149,340,546.8	144,859,577.7
УРСГАЛ ЗАРДАЛ	137,271,770.8	133,263,699.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,009,513.5	76,853,127.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,877,927.1	10,596,216.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,088,685.0	1,208,720.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,233,985.1	1,159,025.9
Хангамж, бараа материалын зардал	890,038.2	1,477,370.6
Нормативт зардал	18,327,184.6	18,347,886.6
Эд хогшил, урсгал засварын зардал	445,408.4	442,856.2
Томилолт, зочны зардал	525,750.9	815,806.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,222,560.1	24,225,926.4
Бараа үйлчилгээний бусад зардал	13,397,974.1	18,579,318.0
ХҮҮ	1,869,998.0	1,320,767.8
ТАТААС	45,424,081.0	53,305,954.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,968,178.3	1,783,849.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,068,776.1	11,595,878.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,925,552.9	66,517,971.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	706,755.3	7,451,136.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	28,739,377.4	5,375,600.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(14,107,069.2)	68,593,506.9

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,743,228.9	-	167,743,228.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	82,288,757.7	-	82,288,757.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	250,031,986.6	-	250,031,986.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,151.8)	-	(2,151.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	6,599.4	-	6,599.4
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	(14,107,069.2)	-	(14,107,069.2)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,929,365.1	-	235,929,365.1
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	235,929,365.1	-	235,929,365.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,063,394.0	-	4,063,394.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	239,992,759.1	-	239,992,759.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(25,111.9)	-	(25,111.9)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	219,942.5	-	219,942.5
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	68,593,506.9	-	68,593,506.9
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	308,781,096.5	-	308,781,096.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	348,121,769.8	565,751,387.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	242,676,689.6	392,838,241.5
Нийтлэг татварын бус орлого	223,204,177.4	385,033,896.8
Тусламжийн орлого	19,472,512.3	7,804,344.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,445,080.2	172,913,145.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	312,128,075.1	388,605,151.0
УРСГАЛ ЗАРДАЛ	312,128,075.1	388,605,151.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,206,159.3	279,817,023.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,302,809.6	13,499,711.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,791,438.0	2,031,151.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,651,932.2	1,241,208.7
Хангамж, бараа материалын зардал	4,263,791.4	3,246,633.2
Нормативт зардал	23,192,104.5	11,797,719.9
Эд хогшил, урсгал засварын зардал	380,138.7	484,321.9
Томилолт, зочны зардал	490,726.6	845,220.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	149,534,448.2	240,404,062.9
Бараа үйлчилгээний бусад зардал	7,598,770.1	6,266,993.2
ХҮҮ	1,254,252.5	-
ТАТААС	81,338,345.4	93,241,014.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,329,317.9	15,547,112.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	35,993,694.7	177,146,236.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	61,802.4	55,479.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	35,166,649.6	49,349,605.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,166,649.6	49,349,605.4
Дотоод эх үүсвэрээр	35,166,649.6	49,349,605.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(35,104,847.2)	(49,294,125.9)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(5,947,473.3)	(98,645,921.8)
Бусад эх үүсвэр	1,465,555.5	67,206.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	7,147,540.5	98,459,622.4
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	265,488.4	253,505.6
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(5,058,625.8)	29,206,188.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,597,182.3	12,538,556.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,538,556.5	41,950,928.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,085,581.2	272,481,713.3	(47,396,132.1)	121.1
УРСГАЛ ЗАРДАЛ	107,339,223.1	99,500,803.2	7,838,419.9	92.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,485,551.6	44,853,841.8	3,631,709.8	92.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,889,229.0	10,510,979.7	378,249.3	96.5
Үндсэн цалин	9,418,317.2	9,249,444.4	168,872.8	98.2
Нэмэгдэл	185,378.4	182,137.5	3,240.9	98.3
Унаа хоолны хөнгөлөлт	674,568.7	644,644.0	29,924.7	95.6
Урамшуулал	18,086.0	12,174.8	5,911.2	67.3
Гэрээт ажлын хөлс	592,878.7	422,579.0	170,299.7	71.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,215,110.8	1,185,696.3	29,414.5	97.6
Тэтгэврийн даатгал	791,259.4	839,730.9	(48,471.5)	106.1
Тэтгэмжийн даатгал	102,771.0	75,641.3	27,129.7	73.6
ҮОМШӨ-ний даатгал	95,440.6	86,002.0	9,438.6	90.1
Ажилгүйдлийн даатгал	20,766.4	18,392.2	2,374.2	88.6
Эрүүл мэндийн даатгал	204,873.4	165,929.9	38,943.5	81.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,336,803.6	1,184,299.4	152,504.2	88.6
Гэрэл, цахилгаан	471,170.1	415,733.2	55,436.9	88.2
Түлш, халаалт	713,922.1	662,687.2	51,234.9	92.8
Цэвэр, бохир ус	68,306.7	47,634.5	20,672.2	69.7
Байрны түрээс	83,404.7	58,244.4	25,160.3	69.8
Хангамж, бараа материалын зардал	618,970.3	596,198.7	22,771.6	96.3
Бичиг хэрэг	106,214.3	101,941.1	4,273.2	96.0
Тээвэр, шатахуун	335,403.6	318,265.3	17,138.3	94.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	121,679.3	116,881.7	4,797.6	96.1
Ном, хэвлэл	385.5	-	385.5	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,876.8	5,276.6	1,600.2	76.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,410.8	53,834.1	(5,423.3)	111.2
Нормативт зардал	11,502,834.4	11,441,384.6	61,449.8	99.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,477,300.5	11,412,435.1	64,865.4	99.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,533.9	28,949.5	(3,415.6)	113.4
Эд хогшил, урсгал засварын зардал	399,448.8	389,549.6	9,899.2	97.5
Багаж, техник, хэрэгсэл	212,386.1	207,965.2	4,420.9	97.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,693.0	7,365.4	327.6	95.7
Урсгал засвар	179,369.7	174,219.1	5,150.6	97.1
Томилолт, зочны зардал	546,365.9	514,927.1	31,438.8	94.2
Гадаад албан томилолт	4,400.0	4,356.4	43.6	99.0
Дотоод албан томилолт	540,697.9	510,570.7	30,127.2	94.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,268.0	-	1,268.0	

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАТ ДҮГНЭЛТ

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,506,291.6	17,494,370.9	2,011,920.7	89.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,397,170.1	17,394,898.1	2,002,272.0	89.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,815.8	9,597.6	218.2	97.8
Даатгалын үйлчилгээ	54,063.8	52,942.0	1,121.8	97.9
Тээврийн хэрэгслийн татвар	17,006.0	15,282.1	1,723.9	89.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,631.3	3,389.1	242.2	93.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,565.8	8,188.2	1,377.6	85.6
Газрын төлбөр	14,939.8	9,984.2	4,955.6	66.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99.0	89.6	9.4	90.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,470,497.2	1,536,435.6	934,061.6	62.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2,465,310.1	1,531,911.3	933,398.8	62.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,187.1	4,524.3	662.8	87.2
ТАТААС	57,500,000.0	53,313,376.3	4,186,623.7	92.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	57,500,000.0	53,313,376.3	4,186,623.7	92.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	57,500,000.0	53,313,376.3	4,186,623.7	92.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,353,671.5	1,333,585.0	20,086.5	98.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	277,584.1	277,408.5	175.6	99.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	277,584.1	277,408.5	175.6	99.9
Бусад урсгал шилжүүлэг	1,076,087.4	1,056,176.5	19,910.9	98.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	121,647.1	120,821.6	825.5	99.3
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	277,000.0	277,000.0	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	312,393.4	301,187.4	11,206.0	96.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	365,046.9	357,167.6	7,879.3	97.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,634,958.1	48,939,180.8	6,695,777.3	88.0
Дотоод эх үүсвэрээр	55,634,958.1	48,939,180.8	6,695,777.3	88.0
Барилга байгууламж	27,546,496.2	22,867,960.8	4,678,535.4	83.0
Их засвар	20,441.7	20,454.5	(12.8)	100.1
Тоног төхөөрөмж	2,278,662.7	1,853,234.7	425,428.0	81.3
Бусад хөрөнгө	3,389,357.5	3,427,908.3	(38,550.8)	101.1
Стратегийн нөөц хөрөнгө	22,400,000.0	20,769,622.5	1,630,377.5	92.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	62,111,400.0	124,041,729.3	(61,930,329.3)	199.7
Эргэж төлөгдөх зээл	61,109,000.0	123,254,387.9	(62,145,387.9)	201.7
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	1,002,400.0	787,341.4	215,058.6	78.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,085,581.2	286,521,015.5	(61,435,434.3)	127.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	186,299,687.8	176,487,863.1	9,811,824.7	94.7
Улсын төсвөөс санхүүжих	186,299,687.8	176,487,863.1	9,811,824.7	94.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	105,905,840.4	113,658,357.6	(7,752,517.2)	107.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,329,910.3	83,609,236.0	16,720,674.3	83.3

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАТ ДҮГИЭЛТ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,300.0	360,888.1	(292,588.1)	528.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	25,848,526.9	-25,848,526.9	
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,507,630.1	3,839,706.6	1,667,923.5	69.7
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	8,880,053.0	7,695,562.6	1,184,490.4	86.7
Хандив тусламж /дотоод/	8,880,053.0	7,695,562.6	1,184,490.4	86.7
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(76,000,000.0)	(11,320,767.8)	(64,679,232.2)	14.9
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(76,000,000.0)	(11,320,767.8)	(64,679,232.2)	14.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,260,665.8	-5,260,665.8	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,094,593.7	-6,094,593.7	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2131	2048	83	96.1
БАЙГУУЛЛАГЫН ТОО	31	30	1	96.8
Төсвийн байгууллага	31	31	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1050	1047	3	99.7
Удирдах ажилтан	67	62	5	92.5
Гүйцэтгэх ажилтан	672	667	5	99.3
Үйлчлэх ажилтан	161	168	-7	104.3
Гэрээт ажилтан	150	150	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1050	1009	41	96.1
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	321	327	-6	101.9
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	580	572	8	98.6
Гэрээт ажилтан	147	146	1	99.3
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**